



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№63
/277/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.03.31

/Тусгай дугаар/

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА






ҮБХИС-ийн АБДС-ийн Эдийн засаг, менежментийн тэнхим нь 2021-2022 оны хичээлийн жилийн дэвшүүлсэн судлаач хамт олон болох зорилтын хүрээнд “Тогтвортой хөгжил-эдийн засгийн аюулгүй байдал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын өнөөдөр зохион байгуулж байна.

Хуралд ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан, Эрдэм, шинжилгээ, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, доктор Б.Өлзийхууг нарын хүндэт зочдоос гадна Монгол улс, ХБНГУ, ОХУ, БНСУ-ын 15 их дээд сургуулийн 60 орчим багш, судлаачид оролцож байгаа юм.

Тус хурлын Үндсэн илтгэлийг ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн дарга докторант Д.Сарангэрэл “Тогтвортой хөгжил: Эдийн засгийн аюулгүй байдлын тулгамдаж буй асуудлууд” сэдвээр илтгэв. Үргэлжлүүлээд “Үндэсний инновацийн тогтолцоо ба, тогтвортой хөгжил”, “Зах зээлийн эдийн засгийн үеийн төрийн бодлого болон санхүүгийн онол, арга зүйн асуудлууд”, “Монгол Улсын эдийн

засгийн аюулгүй байдлыг хангах зарим асуудал”, “Үндэсний аюулгүй байдлын хөрөнгө оруулалтын бодлогоор хангах онол, арга зүйн асуудал”, “Эдийн засгийн өсөлтийг экспортын бус нөлөөлөл ашиглан эконометрикс загвараар тооцоолох нь” зэрэг хэлэлцэх илтгэлүүдээс гадна “Тогтвортой хөгжлийг хангахад төр, хувийн хэвшлийн түншлэлийн нөлөөлөл”, “Системийн удирдлага зохицуулалтын онол, аюулгүй байдал судлалын тулгуур үндэс болох нь”, “Эдийн засгийн аюулгүй байдлыг гадаад худалдааны бодлогоор дэмжих боломж” зэрэг олон сонирхолтой илтгэлүүдийг гадаад дотоодын эрдэмтэн, багш, судлаачид хэлэлцэж байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг хурлыг энэ удаад Монгол улсын төдийгүй олон улсын их, дээд сургуулиудын эрдэмтэн судлаач, профессор багш нарыг оролцуулж тогтвортой хөгжил, эдийн засгийн аюулгүй байдлын талаарх олон асуудлыг хөндөж, гарц шийдлийг эрэлхийлсэн нь хурлын үнэ цэнийг нэмэгдүүлж байлаа.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Д.Сарангэрэл: ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн дарга докторант




Жижиг улсын үндэсний аюулгүй байдлыг хангах дотоод таатай нөхцөл, эдийн засгийн аюулгүй байдлын агуулга нь тогтвортой хөгжлийн асуудал байдаг. Иймээс тогтвортой хөгжилд суурилан эдийн засгийн аюулгүй байдал (ЭЗАБ)-ыг хангах асуудал яригддаг. Орчин

үед олон улсын нөхцөл байдал хурдтай өөрчлөгдөж, нийгэм, эдийн засгийн асуудал, Covid-19 халдварт өвчний тархалт болон бусад зүйлтэй холбоотойгоор улс орны өмнө шинэ сорилт бэрхшээл тулгарч, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад түлхүү анхаарах болсон.

Улсын бүрэн эрхт байдлыг баталгаажуулах арга хэрэгслийг эрэмбэлэхэд нэгд; нийгэм, улс төр, соёлын хөгжил, өвөрмөц байдал, хоёрт; эдийн засгийн нэгдмэл, бие даасан байдал. Хүч чадал, гуравт; төрийн тогтолцооны чадавч, эрх зүйн нэгдмэл байдал, дөрөвт; газар нутгийн бүрэн бүтэн байдал, өөрийгөө батлан хамгаалах чадавч, тавд; гадаад харилцааны чадавч, нэр хүнд багтдаг юм. Тусгаар тогтносон улс бүр эдийн засгийн аюулгүй байдал, эрсдэлийн түвшинг үнэлж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байх шаардлагатай гэдгийг энэхүү өгүүлэлд авч үзсэн болно.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЕИЙН ТӨРИЙН БОДЛОГО БОЛОН САНХҮҮГИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДЛУУД

Д. Болдбаатар: Эдийн засгийн шинжлэх ухааны доктор (Sc.D) профессор, Монгол улсын гавьяат эдийн засагч



Төрийн зохицуулалтын арга хэмжээний үндэс нь эдийн засагт үзүүлэх санхүүгийн туслалцаа, төрийн сангийн хөрөнгө юм. Мөнгөн хөрөнгийн сангийн эргэлт, хөдөлгөөний асуудал нь эдийн засгийн харилцааны онцгой хэлбэр болох санхүүгийн ойлголтод нягт холбоотой билээ. Санхүү нь мөнгө бус, мөнгө үйлчилж байгаатай нөхцөлдөн бий болж, түүний эргэлт, хөдөлгөөний явцад үүссэн эдийн засгийн харилцаа юм. Санхүү нь ямагт оршин тогтнох ба бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, мөнгөний харилцааны хөгжлөөр нөхцөлдсөн, нийгэм, эдийн засгийн байгууллага бүрд байдаг үйлдвэрлэлийн харилцаа юм. Бодит секторт бий болсон нэмүү бүтээгдэхүүн нь санхүүгийн харилцааны үндсэн объект юм. Төрийн санхүүгийн үндсэн категори нь улсын төсөв байдаг.



Төр нь татварын бодлогоор дамжуулан дотоодын бүтээгдэхүүний ажил, үйлчилгээнд нөлөөлдөг. Татвар өндөр байх тутам хүн амд ногдох орлого төчнөөн бага байх, тэр хэмжээгээр худалдан авалт ба хуримтлал хийнэ. Татварын хувь, хэмжээ бага байвал улсын төсөв хооронд орж, төсвийн байгууллага болон нийгэм, соёлын арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэргүй болно. Иймд татварын бодлого нь эдийн засгийн хөгжил, ард түмний аж байдлыг урамшуулах эсвэл сааруулахад хүргэнэ. Ашгийн төлөө ажиллаж буй аж ахуйн нэгжүүд энэ

ҮНДЭСНИЙ ИННОВАЦЫН ТОГТЛОЦОО БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Л.Оюунцэцэг: ШУТИС, Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль (БУХС) Технологийн менежментийн салбарын зөвлөх профессор, доктор (ScD), профессор



Дэлхий дахиныг хамарсан даяаршил, эрчимтэй өөрчлөлтийн өнөөгийн нөхцөлд аливаа улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд шинжлэх ухаан технологи, инновацийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдсээр байна. Улс орнуудын өрсөлдөх чадвар хүн амын тоо, газар

нутгийн хэмжээ, байгалийн баялгаар бус, харин мэдлэг оюунд түшиглэн нөөцөө хэрхэн үр өгөөжтэй ашиглаж байгаагаас ихээхэн хамаарч, үүнд инноваци шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон. Иймээс шинэ санаа, мэдлэгийг үр ашигтай хэрэглээ болгон хувиргахад чиглэгдсэн инновацийн үйл ажиллагаа ихээхэн эрчимжиж, инновацийн чиг баримжаа улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн цоо шинэ хандлагыг тодорхойлж байна. Дэлхий дахины ололт туршлагаас үзэхэд олон улс орон өөрийн онцлог тохирсон инновацийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоо бүрдүүлж хөгжүүлэн багагүй амжилтад хүрээд байна. Үндэсний инновацийн тогтолцоо бол улс орны төрийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх оновчтой механизм, үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийн хангах чухал арга хэрэгсэл юм.

ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ЗАМ

Т.Мөнх-Оргил: ҮБХИС-ийн ЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд хурандаа

Эдийн засгийн аюулгүй байдал нь улс орны үндэсний аюулгүй байдлын зайлшгүй гол бүрдэл хэсэг байхаас гадна аюулгүй байдал болон түүний тогтолцооны бүрэн бүтэн байдлыг хангах материаллаг түшиц болдог билээ. Тэрээр судалгааны ажилдаа дотоод, гадаадын олон эрдэмтэн судлаачдын судалгааны ажилд дүн шинжилгээ хийсэнээс дурвал; "...ЗХУ-ын үндэсний нэгдмэл байдал юм" гэж тодорхойлсон бөгөөд... ЗХУ-ын үндэсний аюулгүй байдалд эдийн засгийн аюулгүй байдал хэрхэн нөлөөлснийг жишээ болгон татаж "1990-ээд оны ЗХУ-ын улс төр, эдийн засгийн тодорхой бус бодлого нь үйлдвэржилтийг 50 хувь бууруулж, хөдөө аж ахуйн салбар нийт бүтээгдэхүүнийхээ 40 хувийг алдаж, ажилгүйдэл дээд цэгт хүрч, төсөв алдагдалд хүрч, улсын өр замбараагүй өссөн нь тогтолцооны хямралыг бий болгож, улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдалд нөлөөлж ЗХУ-ыг задралд оруулсан" мөн "...Тажикстаны эдийн засгийн төдийгүй үндэсний аюулгүй байдлын асуудал анхаарал татаж байна. Учир нь 2011 онд Тажикстаны гадаад өрийг нь цайруулах нэрийдлээр БНХАУ Тажикстаны 1000 гаруй км2 газар нутгийг нь өөртөө нэгтгэж, хэдэн мянган га газрыг түрээсэлж, газар тариалан, төмөр зам тавих нэрийдлээр хэдэн мянган Хятад ажилчдыг байрлуулсан төдийгүй Тажикстаны их дээд сургуулиудад нь Күнзийн институт болон хэлний институтууд байгуулах нийгэм соёлын дипломат бодлогыг идэвхтэй хэрэгжүүлж байна. Ийнхүү эдийн засгийн хэт хамааралтай байдлаас газар нутгийн бага хэсгийг нэгтгэж, багагүй хэсгийг түрээсэлж эхэлсэн бол цаашид хамтын ажиллагааны хүрээнд соёлын бодлого, цэргийн хамтын ажиллагаа ч өргөжиж төлөвтэй байгаа нь нутгийн иргэдийн санаа зовниж буй асуудлын нэг болоод байна" гэх мэтчилэн улс орны аюулгүй байдал нь шууд болон шууд бусаар эдийн засгийн аюулгүй байдалтай холбогдож байгааг судлан

тодорхойлсон байдаг. Тиймээс улс орны эдийн засгийн аюулгүй байдал нь үндэстэн оршин тогтнох нэг чухал тулгуур юм. Даяаршлын нөлөөгөөр улс орнуудын үндэсний эдийн засаг нь дэлхийн эдийн засгийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болж, харилцан хамааралтай болсон нь нэг талаар тухайн орны хөгжлийг түргэтгэх хүчин зүйл болж байгаа боловч нөгөө талаас ҮАБ-ыг гадаад, дотоод сөрөг хүчин зүйлүүдийн нөлөөллөөс хамгаалах шаардлагыг нэмэгдүүлж байна. Үндэсний аюулгүй байдлын нэг тулгуур болох эдийн засгийн аюулгүй байдалаа үндэсний язгуур эрх ашигтайгаа нийцүүлэн хангах зорилгыг улс орон бүр өөр өөрийн онцлог тохирсон бодлого, үзэл баримтлалаар хэрэгжүүлж байгаа юм. Үүнээс шалтгаалан эдийн засгийн аюулгүй байдлын агуулгыг тодорхойлоход улс орнуудын байр суурь ч харилцан адилгүй байна. Хөгжингүй орнууд зах зээлээ хамгаалах, эдийн засгийн өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд голлон анхаарч байхад, хөгжиж буй улс орнууд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, ядуурал, ажилгүйдлийг багасгахад хүчин чармайлтаа төвлөрүүлж байна. Тухайлбал, АНУ, БНХАУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй улсууд дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараараа тэргүүлэхийг эрмэлзэж байхад, Казахстан Улсын хувьд эдийн засгийн аюулгүй байдал гэсэн нэр томьёо нь эдийн засгийн тогтвортой өсөлт, олон улсын зах зээл дэх баттай байр суурийн тухай санааг илэрхийлсэн жирийн утгаар хэрэглэгддэг бөгөөд үүнийгээ хангахын тулд байгалийн нөхөн сэргээгдэхгүй нөөц, анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн экспортолыг аль болох багасгах, экспортыг хөгжүүлэх хэтийн зорилт нь өндөр үнэтэй экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх, үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нь өрсөлдөх чадвараа өсгөхийн тулд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг боловсруулах аж үйлдвэрлэлийг шинэчлэхэд

зориулан үүнийгээ төрийн бодлого болгон хэрэгжүүлж байна. Манай улсын эдийн засаг төрөлжөөгүй зөвхөн уул уурхайгаас хамааралтай, түлш болон эрчим хүч экспортлогч орны монополь эрхэнд орсон, зарим төрлийн хүнс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн тухайлбал, цагаан будаа, жимс жимсгэнэ, цаашлаад эм, зүүлл мөндийн бүтээгдэхүүн, авто машин, хүнд машин механизмны импорттоос бүрэн хараат байдалтай байна. орхойлж, хэрэгжүүлж чадаагүйтэй шууд холбоотой юм. Аюулгүй байдлын орчин өндөр хурдацтай хувьсан өөрчлөгдөж, уламжлалт ба уламжлалт бус аюул заналын цар хүрээ өргөжиж тэлж байгаа байдлыг харгалзах нь аюулгүй байдлыг хангах чухал хүчин зүйл болохыг хөгжлийн бодлогод тооцох шаардлагатай гэж үзээд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, батлан хамгаалах зэрэг арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохицуулалтын цогц тогтолцоо чухал болохыг онцолж байна.

ЭДИЙН ЗАСАГ, МЕНЕЖМЕНТИЙН ТЭНХИМИЙН ТАНИЛЦУУЛГА

Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль нь 2015 оны 07 сард Батлан Хамгаалахын сайдын тушаалаар бүтцийн өөрчлөлт хийж, Аюулгүй Байдлын Сургуулийн бүтцэд хоёр тэнхим /Төрийн захиргаа эрх зүйн, Ар тал эдийн засгийн/ ийг өргөтгөж, Менежмент, эдийн засгийн тэнхимийг байгуулсан. 2017 онд нэршлийн хувьд Эдийн засаг, менежментийн тэнхим байгуулагджээ.

Эдийн засаг, менежментийн тэнхим нь "Төрийн удирдлага", "Эдийн засаг", "Менежмент" хөтөлбөрөөр бакалаврын боловсролын "Төрийн удирдлага" хөтөлбөрөөр магистрын боловсрол олгох сургалтыг явуулж байна. Дээрх хөтөлбөрөөр суралцагсад бакалаврын боловсрол олгох сургалтын загвар шаардлагад нийцүүлэн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлдүүдийг төлөвлөн онол арга

зүйн мэдлэг, чадварыг эзэмшүүлж байна. Түүнчлэн хөтөлбөрийн онцлогт тохирсон танилцах болон мэргэжлийн, үйлдвэрлэлийн дадлагыг төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад гүйцэтгэж онолын мэдлэгийг практикт хэрэглэх дадал, чадамжийг эзэмшиж байна.

Менежмент, эдийн засгийн тэнхим нь УБХИС-ийн АБС-ийн хичээлийн I байранд нийт 25 бүлгийн 900 гаруй суралцагсад 18 профессор багш нар хөтөлбөрөөр боловсрол олгох үйлчилгээ үзүүлдэг. Нийт багш нарын 11,1% нь докторын зэрэгтэй, 77,8% нь докторант 5,5% нь 3-5 жил ажилласан багш, 27,8% нь 20-25 жил ажилласан багш эзэлж, 77,8% нь салбарын тэргүүний ажилтнаар, 27,8% нь төрийн одон медалиар шагнагдсан.



БИДНИЙ БАХАРХАЛ: Манай хамт олон УБХИС-нараа, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай "Төрийн удирдлага", "Эдийн засаг", "Менежмент" хөтөлбөрүүдээрээ, нийт суралцагсад, төгсөгчид шавь нараараа бахархдаг.

ТЭНХИМИЙН СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ

- Улсын салбарын менежмент, засаглал
- Эдийн засгийн аюулгүй байдал

ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ

- Харьцуулсан төрийн захиргаа
- Төрийн удирдлагын бодлого, хөгжил
- Глобал засаглал
- Сайн засаглал
- Нутгийн өөрийн удирдлага
- Тогтвортой хөгжил: Компанийн засаглал
- Олон нийттэй харилцах харилцаа, нийгмийн түншлэл
- Инновац, Гүйцэтгэл үр дүнгийн удирдлага
- Бүтээмж, чанарын удирдлага

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

- Төрийн албан хаагчдын хөгжил, манлайлал
- Хувь хүний хөгжил, манлайлал
- Төрийн захиргааны шинэтгэл
- Хүний нөөцийн удирдлага
- Орон нутгийн санхүү төсвийн удирдлага
- Инновацийн удирдлага
- Бүтээмж, чанарын удирдлага
- Худалдан авах ажиллагаа
- Үйлчилгээний маркетинг
- Төслийн удирдлага
- Байгууллагын засаглал
- Албан хэрэг хөтлөх үр чадвар

БИДНИЙ АМЖИЛТ

- ЭЗМТ нь 2016-2017 онд хөтөлбөрийн тогтвортой хөгжлийг хангаж хөтөлбөрүүдэд тодотгол хийсэн. 2018 онд ижил хөтөлбөр хэрэгжүүлдэг их дээд сургуулиудын багш нарын дунд "Хөтөлбөрийн тогтвортой байдал" сэдвээр хэлэлцүүлэг, "Дээд боловсрол-Орчин үе" сэдэвт салбарын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан. Мөн тус ондоо Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар "Менежмент" хөтөлбөрийг хэлэлцүүлж батлуулсан.

- 2019 онд УБХИС-ийн сургалтын хэлтэстэй хамтран "Оюутанд үйлчилгээ үзүүлэх нэгдсэн төв" байгуулах төсөл боловсруулав. 2020 онд Удирдахуйн ухаанаар мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 20 жилийн бүтээлч ойг тэмдэглэн "Удирдахуйн ухаанаар мэргэжил бэлтгэсний 20 жил: туршлага, сургаж" сэдэвт онол, практикийн бага хурал зохион байгуулав.

- 2020-2021 онуудад нийт багш нарын 38,8% нь ОХУ, Вьетнам, Япон, Энэтхэг, БНСУ-д зохион байгуулагдсан Олон улсын эрдэм шинжилгээний хуралд, 57,8% нь улс, салбарын эрдэм шинжилгээний хуралд оролцож, 42,1% нь Олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд, 22,2% нь IF зэрэглэлийн сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэв.

- 2021 онд "СЭЗИС-тай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийн анхны төгсөлт болов_ Иөн тус ондоо АБДС-ийн тэргүүний тэнхим"-ээр, "УБХИС-ийн дэд тэргүүний тэнхим"-ээр тус тус шалгарсан.

- 2021 онд тэнхимийн даргын санаачилгаар 5 багшийн бүрэлдэхүүнтэй баг Cesim компанийн олон улсын түвшинд зохион байгуулагддаг "Global Challenge Simulation" онлайн тэмцээнд амжилттай оролцсон.

- 2022 оны 03 сарын 17 өдөр "XXI зууны оюутны хөгжил, манлайлал" сэдэвт салбарын оюутны эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. 2022 оны 3 дугаар сарын 31 өдөр "Тогтвортой хөгжил: Эдийн засгийн аюулгүй байдал" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна.

- ЭЗМТ Багш С.Туул 2015 онд "БХИС-ийн тэргүүний багш"-аар, 2016 онд "Монголын их дээд сургуулиудын консорциумын

тэргүүний багш"-аар тус тус шалгарсан. 2017 онд "Payment Balance of Mongolia and Its Impact of Economic Independence" сэдвээр БНСУ-д зохион байгуулагдсан "Seoul International Conference on Social Science and Management" олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн.

- Профессор багш Д.Энхчимэг 2016 онд Аюулгүй байдал судлалын докторын зэрэг хамгаалсан, 2018 онд "УБХИС-ийн тэргүүний багш"-аар, 2021 онд "УБХИС-ийн тэргүүний судлаач багш"-аар тус тус шалгарсан.

- 2017 онд багш Д.Оюунбилэг УБХИС-ийн тэргүүний багш шалгаруулах уралдаанд "Тэргүүний залуу багшийн дэд байр"-т шалгарч, 2021 онд Аюулгүй байдал судлалын докторын зэрэг хамгаалсан.

- Багш З.Хандмаа 2017 онд "АБС-ийн тэргүүний заах арга зүйч багшийн дэд байр"-д шалгарсан.

- 2020 онд ахлах багш Ш.Гантуяа, багш Д.Гандолгор БНСУ-д 560 дахь удаагаа зохиогдож буй "560th International Conference on Management, Economics & Social Science-ICMESS 2020" олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцсон.

ТӨСӨЛТ БОЛОН СУДАЛГААНЫ ДААЛГАВАРТ АЖИЛ

- Хөтөлбөр, төсөлт ажил:
- "Оюутны дуу хоолой" радио уэль төсөл /БСШУСЯ болон Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй/
 - "Технологи ба сурах орчин" төсөл /БСШУСЯ болон Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй/
 - "Аялгуут хонх" төсөл /БСШУСЯ болон Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй/
 - Сургалт судалгааны хөгжлийн төв /УБХИС-ийн санхүүжилтээр/
 - "Ус цэвэршүүлэх" төсөл /УБХИС-ийн санхүүжилтээр/
 - Дадлагын танхим /УБХИС-ийн ЭЗМТ-ийн төгсөгчдийн санхүүжилтээр/
 - Эдийн засаг, менежментийн тэнхимийн багшийн хөгжлийн өрөө хөтөлбөр
 - XXI зууны оюутны хөгжил-манлайлал хөтөлбөр
 - Судалгааны даалгаварт ажил:
 - Цахим-мини номын сан
 - Эдийн засгийн аюулгүй байдал
 - Чанарын удирдлага менежментийг сайжруулах Excellence үйлчилгээ

ОЮУТНУУДЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Оюутан, суралцагсдыг олон улсын болон улс, салбарын эрдэм шинжилгээний хурлуудад оролцох боломж нөхцөлөөр хангадаг.

- Тэнхимийн оюутан, суралцагсдын дунд эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулж хэвшсэн.

- Оюутны санаачилсан үйл ажиллагаа, тэмцээн уралдааныг дэмжин идэвхжүүлдэг.

- Оюутан, суралцагсдын санал хүсэлт дээр үндэслэн хамтран ажилладаг байгууллагуудтай уулзалт ярилцлагыг тогтмол зохион байгуулдаг.

- Оюутнуудын санаачилсан Цэнэг, Амьдрах ухаан судлал, Менежер, Хөгжил, Судлаач оюутан клубийн үйл ажиллагааг дэмжин арга зүйгээр хангаж, оюутны идэвх оролцоог урамшуулж байна.

- Хичээлийн жил бүр "Мэргэжил сурталчлах өдөрлөг"-ийг зохион байгуулж оюутнуудад зөвлөгөө, мэдээлэл өгдөг.

- Оюутнуудын эх оронч үзэл, сэтгэлгээ хандлагыг төлөвшүүлэх зорилгоор "Дээлтэй Монгол" өдөрлөгийг тогтмол зохион байгуулан явуулдаг.

- Тэнхимийн шилдэг оюутнуудыг тогтмол тодруулж алдаршуулж, урамшуулдаг.

ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦСАНЫ ДАВУУ ТАЛ, БОЛОМЖ

- Хөтөлбөрийн боловсрол эзэмшсэн, онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх чадвар чадамжийг эзэмших;

- Хөтөлбөрт холбогдох шинжлэх ухааны салбарт гадаад, дотоодын байгууллагад, хүлээн зөвшөөрөгдсөн, хүндэтгэл хүлээсэн эрдэмтэн, багш нараар хичээл заалгах;

- "Иргэдийн төлөөлөгчдийн хурал"-ын болон "Засаг даргын тамгын газар"-ын дадлагын "Эдийн засгийн мэдээлэл боловсруулах, санхүү төсвийн бүртгэл хийх" кейс танхимуудад оюутны бие даасан ажлыг хийж гүйцэтгэх;

- Танилцах, мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлагуудыг төрийн, бизнесийн, олон нийтийн байгууллагуудад хийх боломж нөхцөлөөр хангагдана.

- Хөтөлбөрөөр амжилттай суралцаж буй оюутнууд гадаадын их дээд сургуулиудад шилжин суралцах боломжтой.

- Хичээлийн бус цагаар УБХИС-ийн Гадаад хэлний төв дээр Англи, Герман, Орос, Солонгос, Турк, Хятад хэл сурах боломжтой.

- Батлан хамгаалах сайдын тушаалаар батлагдсан дүрэмт хувцас өмсөж, жигдэрдэг.


- Эрэгтэй оюутан суралцах хугацаандаа цэргийн анхан шатны бэлтгэлд хамрагдаж, цэргийн алба хаасанд тооцогдоно.

- Аль ч байгууллагад хөтөлбөрийн боловсрол эзэмшсэн чиглэлээр ажиллах боломжтой.

- Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад болон дотоодод төгсөлтийн дараах сургалтад хамрагдах боломж нээлттэй.

ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД

- Батлан хамгаалах яам
- Боловсрол соёл шинжлэх ухааны яам
- Байгаль орчин ногоон хөгжлийн яам
- Төрийн албаны зөвлөл
- Зэвсэгт хүчний Жанжин штаб
- Монгол банк
- Үндэсний аудитын газар
- Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын тамгын газар
- Нийслэлийн дүүргүүдийн татварын алба
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар Удирдлагын Академи
- Үндэсний тагнуулын академи
- Олон улсын Royal академи
- Монгол улсын их сургууль
- Шинжлэх ухаан технологийн их сургууль
- Хөдөө аж ахуйн их сургууль
- Санхүү эдийн засгийн их сургууль
- Хууль сахиулахын их сургууль
- Монголын үндэсний их сургууль
- Цэцэг гүн дээд сургууль
- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
- Боловсролын үнэлгээний төв
- Конрад-Аденауер сан
- Монголын менежментийн холбоо
- Нутгийн удирдлагын холбоо
- Монголын залуучуудын холбоо
- Монголын улаан загалмай нийгэмлэг
- Татварын мэргэшсэн зөвлөхүүдийн нийгэмлэг



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)